



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

┌ Сургалт зохион байгуулах тухай ┐


Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.7.6, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай зочид буудлуудын менежер, аюулгүй байдал, хамгаалалтын албаны дарга нарт зориулсан "Зочид буудлын аюулгүй байдал, хамгаалалт, гамшгийн эрсдлийн менежмент" сэдэвт сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын төсөв болох 690,000 /зургаан зуун ерэн мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад зөвшөөрсүгэй.


3. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн Ш.Ундармаад үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2015 оны 05 сарын 21 ний өдрийн 174 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



**"ЗОЧИД БУУДЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМГААЛАЛТ, ГАМШГИЙН
ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ" СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Зорилго: "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай зочид буудлын барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах, үйлчлүүлж буй гадаад, дотоодын иргэд, жуулчдын эрүүл аюулгүй орчинд буудаллах нөхцөлийг бүрдүүлэх, учирч болзошгүй эрсдлийг бууруулах, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх, ажил үйлчилгээ үзүүлж байгаа тухайн байгууллагын ажилчдад гамшгийн нөхцөл байдал үүссэн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг ур чадварыг эзэмшүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын түншлэгч зочид буудлуудын менежер, аюулгүй байдал, хамгаалалтын албаны дарга, ажилтнууд хамрагдана.

Хугацаа: 2015 оны 05-р сарын 21-ний өдөр

Сургалт болох газар: "Улаанбаатар" зочид буудал

Сургалтын хөтөлбөр:

09.00-09.30 Бүртгэл

09.30-09.40 Нээлтийн ажиллагаа

НАЖГ-ын дарга Э.Баттулга

Монголын зочид буудлуудын холбооны тэргүүн С.Мөнхбат

Монголын зочид буудлуудын холбооны гүйцэтгэх захирал

Н.Батцэнгэл

09:40-10:00 "Зочид буудлын барилга байгууламжийн аюулгүй байдалд тавих шаардлагууд" илтгэгч, "Обзерв консалтинг" ХХК-ийн захирал Д.Отгонбат

10:00-10:30 "Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" илтгэгч, "Обзерв консалтинг"-ХХК-ийн менежер Д.Мөнхбаяр

10:30-11:00 "Зочид буудлын зочны аюулгүй байдлын хангах асуудал" илтгэгч, "Кемпински" зочид буудлын зочинтой харилцах хэсгийн менежер Б.Ариунганга

11:00-11:30 "Гамшгийн асуудал-Гал усны аюулгүй байдал" илтгэгч, ОБЕГ-ын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Д.Алтанабагана

11:30-11:50 Цайны завсарлага

11:50-12:20 "Аюулгүй байдал, хамгаалалтын асуудлууд" илтгэгч, Төрийн тусгай хамгаалалтын газрын сургалтын мэргэжилтэн Ж.Ганзориг

12:20-12:50 "Lost and found" үйлчилгээний менежмент, илтгэгч "Рамада" зочид

буудлын Зочин Угтах хэлтсийн менежер Г.Дэлгэрмөрөн

12:50-13:10 “Зочид буудлуудад нөөцийн цахилгаан үүсгүүр тавих шаардлага болон шийдлүүд” илтгэгч, “Вагнер Ази” ХХК-ийн инженер Б.Баяндаваа

13:10-13:20 Хаалт:


Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Ш.Ундармаа

Монголын зочид буудлуудын холбооны гүйцэтгэх захирал

Н.Батцэнгэл

Хүрэх үр дүн: Зочдын аюулгүй байдлын хангах, учирч болзошгүй эрсдлийг бууруулах, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх ажлын үр дүн дээшилсэн байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2015 оны 05 сарын 21-ний өдрийн 1441 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт



"ЗОЧИД БУУДЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМГААЛАЛТ, ГАМШГИЙН
ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ" СЭДЭВТ СУРГАЛТЫН ТӨСӨВ

д/д	Зардлын зүйл	Тоо, хэмжээ	Нэгж зардал/төг/	Нийт зардал /төг/
1	Багшийн төлбөр	7	50,000	350,000
2	Сургалтын цай, кофены зардал	60	5000	300,000
7	Цэвэр ус	80	500	40,000
	НИЙТ			690,000

Хянасан: Ахлах нягтлан бодогч

П.Ариунаа

Боловсруулсан: Мэргэжилтэн

Ш.Ундармаа